

АВЛИГЫН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЗАЙЛШГҮЙ ТУСГАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025.01.20

№	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн байдал
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Шудрага байдлын үнэлгээг 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх							
1	Арга хэмжээ 1.1. Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын үйл явц дахь авлигын хэлбэр, шалтгаан, нөхцөлийг тодорхойлох зорилгоор судалгаа, дүн шинжилгээ хийх;	-	Шудрага байдлын үнэлгээний оноо	75.3	82.8	2024 оны II хагас-2025.02.01	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас биржээр ил тод бүтээгдэхүүнийг борлуулах эрх зүйн орчныг нь бүрдүүлж Биржийн тухай хуулийн төслийг боловсруулан батлуулсан. Дээрх хуулийн 10 дугаар зүйлд заасан төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН-д болон Монголын хөрөнгийн бирж арилжааг зохион байгуулах бөгөөд арилжааны хяналтад Санхүүгийн зохицуулах хяналт тавих зохицуулалттай тул энэхүү арга хэмжээний хэрэгжилт болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг СЗХ-ноос гаргах нь зүйтэй юм.
2	Арга хэмжээ 1.2. Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 17 дугаар нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;	-	Шудрага байдлын үнэлгээний оноо	75.3	82.8	2024 оны II хагас-2025.02.01	Монголын ОУИТБС-ын Ажлын албыг 2019 оны эхээр Ерөнхий Сайдын ажлын албанаас хуучин нэрээр Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд шилжүүлсэн. Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Азийн хөгжлийн банк Монголын ОУИТБС-ын үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Олборлох салбарын засаглалыг

						сайжруулах ТА 9752 MON" төслийн гэрээг 2019 оны 7 дугаар сард байгуулж, хэрэгжүүлсэн. Мөн Дэлхийн банк, Сангийн яам "ОУИТБС-ыг хэрэгжүүлэх замаар олборлох салбарын ил тод байдлыг сайжруулах Р176874" тоот төслийн гэрээг 2022 оны 5 дугаар сард байгуулж, ОУИТБС-ын Ажлын албыг төсөл хэрэгжүүлэх нэгжээр ажиллуулахаар тохирон 2022 оны 10-р сард эхлүүлж төслийг 2023 оны 12-р сарын 31-нд хэрэгжүүлж дуусгасан. Харин 2024 оны 1-р сарын 1-нээс эхлэн үйл ажиллагаа дан ганц Улсын төсвөөр санхүүжиж, 2025 онд үргэлжлүүлэхээр боллоо. Дээрх үйл ажиллагааны үр дүнд Монголын ОУИТБС-ын үйл ажиллагаа нэлээд жигдэрсэн бөгөөд ОУИТБС-ыг стандартын дагуу бэлтгэдэг жил бүрийн нэгтгэл тайлангуудыг хугацаандаа гаргадаг болсон. Үүнд: - 2019 оны эцсээр 2018 оны нэгтгэл буюу 13 дугаар тайлан, - 2020 оны эцсээр 2019 оны нэгтгэл буюу 14 дүгээр тайлан, - 2021 оны эцсээр 2020 оны нэгтгэл буюу 15 дугаар тайлан, - 2022 онд 2021 оны нэгтгэл буюу 16 дугаар тайлан, - 2023 онд 2022 оны нэгтгэл буюу 17 дугаар тайлан,
--	--	--	--	--	--	---

						- 2024 онд 2023 оны нэгтгэл буюу 18 дугаар тайланг монгол, англи хэл дээр тус тус боловсруулан батлуулж, хэвлэн нийтэлсэн байна. ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах /17 дугаар нэгтгэл тайлан/ ОУИТБС-ын 2023 оны тайлагнал Ажлын албаны тооцоолсноор ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны гэрээлэгч 2159 компани буюу зөвхөн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 1027, зөвхөн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 777, ашиглалтын болон хайгуулын лиценз эзэмшигч 340, үүсмэл орд эзэмшигч 1, бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий 17 компани ОУИТБС-ын 2023 оны тайлангаа шинэ маягтаар гаргана гэсэн тооцоололтой байсан. ОУИТБС-ын тайлангаа 1096 компани ОУИТБС-ын цахим тайлагналын системээр гаргасан нь сүүлийн жилүүдийн хамгийн бага тоо болж байна. Ажлын албанаас 2023 оны тайлангаа гаргах албан хүсэлтийг 2 яам, 7 агентлаг (татвар, ашигт малтмал, газрын тос, гааль, төрийн өмч, хөдөлмөр нийгмийн халамж, стандарт хэмжил зүй, нийгмийн даатгал, халамж), 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт илгээж,
--	--	--	--	--	--	---

							Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын системээр гаргах аргачлалыг холбогдох маягт, зааварчилгаа, нэвтрэх нууц үгийн хамт хүргүүлсэн байна. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд одоогийн байдлаар 5 агентлаг (Татварын ерөнхий газар, Улсын стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын алба, Ашигт малтмал, газрын тосны газар, Гаалийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар), 18 аймаг, 8 дүүрэг ОУИТБС-ын тайлангаа 2093 компаниас хүлээн авсан орлогын дүнгээр гаргасан байна.
3	Арга хэмжээ 1.4. Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулах.	-	Шудрага байдлын үнэлгээний оноо	75.3	82.8	2024 оны II хагас-2025.02.01	Аж үйлдвэр, геологи, уул уурхай, газрын тосны чиглэлээр Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.6, 8.7, 8.8, 8.9, 8.10-д тусгасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас олгодог тусгай зөвшөөрлүүдийг Гааль, татвар, санхүү, мэдээллийн технологийн төвтэй хамтран бүрэн цахимжуулж, Зөвшөөрлийн цахим систем (https://license.mn/)-д шилжүүлсэн.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

ТЗУГ-ЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

С.ЖАВХЛАНБААТАР

Ц.БАТЦАЙЗ

Т.ГАНБААТАР